**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 23 өдөр — Дугаар А/42 — Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 260 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 262 дугаар зүйлийн 1.2, Монгол Улсын Засгийн газрын "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" 143 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр"-ийг нэгдүгээр, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг зохих зардлаас гаргахыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа Н.Цэвэлмаа/-т зөвшөөрсүгэй.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг алба, газар, хэлтэс, хорих анги, байгууллагын дарга нарт, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа С.Батбямба/-т тус тус даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА Д.ЗАГДЖАВ

1501011202

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23 - ны өдрийн А/42 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР
/2021-2024/

## Нэг. Нийтлэг үндэслэл

### Хөтөлбөрийн зорилго

1.1. Хөтөлбөрийн зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хөгжүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэн иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах, байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэмлэмжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## Хоёр. Эрх зүйн үндэслэл

2.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр нь /цаашид хөтөлбөр гэх/ дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдана. Үүнд:

2.1.1. Төрийн албаны тухай хууль;
2.1.2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
2.1.3. Монгол Улсын Засгийн газрын “Ил тод байдлыг хангах, шалгуур үзүүлэлтийг хангах” 143 дугаар тогтоол;
2.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

## Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

3.1.1. Хөтөлбөр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц байх;

3.1.2. Хөтөлбөрийн зорилтууд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахуйц байх;

3.1.3. Хөтөлбөрийн арга хэмжээнүүд нь хуулиар нууцад тооцогдсоноос бусад асуудлаар байх;

3.1.4. Хөтөлбөрийн арга хэмжээнүүд нь байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, зорилго, зорилтууд, түүний хэрэгжилт, хүрч буй үр дүнтэй уялдсан байх;

3.1.5. Хөтөлбөрийн арга хэмжээнүүд нь бодитой, иргэд, олон нийтэд мэдлэг, мэдээлэл болохуйц байх.

## Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шийдвэрлэж буй асуудлын цар хүрээ, нийгмийн ач холбогдол жилээс жилд өргөжиж, үүнтэй уялдан байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, бодлого чиглэл, үйл ажиллагааг хүртээмжтэй, цогц хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх зүй ёсны шаардлага бий болсон.

### Стратегийн зорилтууд

4.2. Хөтөлбөрийг дараах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

**Зорилт 1.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг хуулийн хүрээнд олон нийтэд шуурхай, ил тод хэлбэрээр хүргэх ажлыг эрчимжүүлэх;

**Зорилт 2.** Иргэд, олон нийтийн санаа бодол, байгууллагын үйл ажиллагаанд өгөх үнэлэмжийг тогтмол судалж, дүн шинжилгээ хийх, үр дүнг байгууллагын төлөвлөлт, бодлогын баримт бичигт тусгах ажлыг тогтмолжуулах;

**Зорилт 3.** Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай олон талт харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

**Зорилт 4.** Иргэд, олон нийтэд хүргэж байгаа байгууллагын үйл ажиллагааны талаар бэлтгэн боловсруулж буй мэдээ, мэдээллийн төрөл, арга хэлбэр, нийтлэлийн бодлогыг шинэчилж, мэргэжлийн түвшинд хүргэх замаар агуулга, хүртээмжийг сайжруулах;

**Зорилт 5.** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дотоодын сургалт, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.

## Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Дээрх зорилт тус бүрийн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг хуулийн хүрээнд олон нийтэд шуурхай, ил тод хэлбэрээр хүргэх ажлыг эрчимжүүлэх **нэгдүгээр дүгээр зорилтын хүрээнд:** /2021-2024 он/

- Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, мэдээ мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулан, мэдээлэл авах хэлбэрийг хялбаршуулах ажлыг эрчимжүүлэх; /2021-2024 он/

- Мэдээлэл авахыг хүссэн иргэд, байгууллагад хуулиар зохицуулснаас бусад мэдээллийг түргэн шуурхай өгөх ажлыг төв байгууллага болон салбар нэгжийн хүрээнд тогтмолжуулах; /2021-2024 он/

- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны болон цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг түргэн шуурхай бэлтгэн түгээж, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах; /2021-2024 он/

- Байгууллагын цахим хуудаст иргэд, олон нийт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал сэтгэгдэл илэрхийлэх, түүнд хариу өгөх нөхцөлийг бүрдүүлэх. /2021-2022 он/

- Иргэдийг мэдээллээр тогтвортой хангах чиг үүргийг тодорхой албан тушаалтанд хариуцуулан ажиллуулах, нийт ажил хариуцсан алба хаагчид тус тусын чиг үүргийнхээ хүрээнд мэдээллийг шуурхай өгөх эрх зүй, зохион байгуулалтыг бий болгох; /2021-2022 он/

- Нийгмийн сүлжээнд тулгуурлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх суваг, гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх; /2021-2022 он/

- Иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх, байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж, шийдвэрлүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллээр иргэдийг хангах мэдээлэл авах хэсэг, орчны хөгжүүлэлтийг хийж, санал хүсэлтийг тогтмол авах; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд түргэн шуурхай өгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цахим программ хангамжийг шинээр боловсруулан хөгжүүлэлтийг хийх; /2021-2024 он/

- Иргэдийг түргэн шуурхай мэдээллээр хангахгүй байх, чирэгдэл учруулах, хохироохоос урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох;/2021-2024 он/

5.1.2. Иргэд, олон нийтийн санаа бодол, байгууллагын үйл ажиллагаанд өгөх үнэлэмжийг тогтмол судалж, дүн шинжилгээ хийх, үр дүнг байгууллагын төлөвлөлт, бодлогын бичиг баримтад тусгах ажлыг тогтмолжуулах **хоёрдугаар зорилтын хүрээнд:**

- Байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэмлэмжийг үнэн зөвөөр судлан тогтоох аргачлалыг боловсруулан баталж хэрэгжүүлэх; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн үнэлэмжийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж, тогтмолжуулах; /2021-2022 он/

- Судалгаа шинжилгээний үр дүнд суурилан өөрчлөх, сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган боловсруулан баталж, эрх зүйн зохицуулалтыг бий болгох; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх ажлыг тусган батлуулж, мөрдөн ажиллах; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон салбар нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх, түүнийг үнэлэх, тодорхой үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах талаар бүлэг, заалтыг тусгуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийх; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэхэд баримтлах журмыг боловсруулан батлуулах; /2021-2022 он/

- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны санхүү төсөв, орон тоо, шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэх саналыг агентлагийн хэмжээнд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүсэлтийг хүргүүлэн шийдвэрлүүлэх; /2021-2024 он/

- 5.1.3. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай олон талт харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх **гуравдугаар зорилтын хүрээнд:**

- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ил тод, нээлттэй, түргэн шуурхай авах ажлыг үр дүнд хүргэх зорилго бүхий санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн бүхий л төрлийн байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг тогтмолжуулах; /2022-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагааас Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх, эерэг үр дүнг бий болгох гэрээ, санамж бичгийг байгуулах; /2021-2024 он/

- Байгууллагын үйл ажиллагааны талаар бэлтгэсэн дүрст контентуудыг телевизүүдийн хөтөлбөрт тогтмол тусгах замаар иргэдийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг танилцуулах, салбарын ололт амжилтыг сурталчлах ажлыг тодорхой хугацаанд зохион байгуулах; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг илүү өргөн хүрээтэй олон нийтэд хүргэх зорилгоор мэргэжлийн чиглэл тус бүрийн онцлогийг харуулсан хөтөлбөр, аян, зорилтот контентуудыг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулах; /2021-2024 он/

5.1.4. Иргэд, олон нийтэд хүргэж байгаа байгууллагын үйл ажиллагааны талаар бэлтгэн боловсруулж буй мэдээ, мэдээллийн төрөл, арга хэлбэр, нийтлэлийн бодлогыг шинэчилж, мэргэжлийн түвшинд хүргэх замаар агуулга, хүртээмжийг сайжруулах **дөрөвдүгээр зорилтын хүрээнд:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлт, үр дүнгийн талаарх мэдээллийг агуулсан видео контент бэлтгэн нийтлэх ажлыг тогтмолжуулах; /2021-2022 он/

- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, сурвалжилга, ярилцлага, нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэн өдөр тутмын сонин, сайтад нийтлүүлэх ажлыг нэмэгдүүлэх; /2021-2022 он/

- Телевиз /дотооддоо үйл ажиллагаа явуулдаг/, радио, fm, фэйсбүүк, твитер, инстеграм, влог, подкастад зориулсан мэдээ, мэдээллийг төрөлжүүлэн бэлтгэн түгээх ажлыг эрчимжүүлэх; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчдын ажил албаны үйл ажиллагааны талаар фото сурвалжилга бэлтгэн өдөр тутмын сонин, сайт болон байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст нийтлэх; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн мэдээллийн хэрэгсэл болох "Сүлд инфо" сэтгүүлийн нийтлэлийн бодлого холбогдох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан, мөрдөн ажиллах; /2021-2022 он/

- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвөөс алба хаагч, иргэд, олон нийттэй редакцын уулзалт зохион байгуулах, нийт бие бүрэлдэхүүнд хэрэгцээ, шаардлагатай, тулгамдаж буй асуудлаар санал солилцох, санал, шүүмжийн мөрөөр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах; /2021-2022 он/

- Байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааны ололт амжилтыг илэрхийлсэн онол, арга зүйн ном, товихмол, эмхэтгэл, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл гаргах ажлыг хөхиүлэн дэмжиж, сурталчлах; /2021-2024 он/

5.1.6. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дотоодын сургалт, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх **тавдугаар зорилтын хүрээнд:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагын хэвлэл мэдээлэл хариуцсан алба хаагчдыг чадавхжуулах, мэдээ, мэдээллийг стандарт шаардлагын дагуу бэлтгэн, түгээх чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах; /2021-2022 он/

- Хэвлэл мэдээлэл хариуцсан алба хаагчдыг чадавхжуулах, гэрэл зургийг стандартын дагуу авах, орчин үеийн техник хэрэгсэлтэй харилцахад чиглэсэн зөвлөмж, гарын авлага боловсруулан гаргах; /2021-2022 он/

- Алба хаагчдыг байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд зөв ойлголт өгөхүйц ажил, арга хэмжээ зохион байгуулах, сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, өргөжүүлэх чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдыг илтгэх, ярианы ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах; /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль, журам, дүрмийн талаар сэтгүүлчдэд сургалт зохион байгуулах. /2021-2022 он/

## Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

6.1. Тус хөтөлбөрийг 2021-2024 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

## Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

7.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа хорих анги, газар, салбар нэгжийн жил бүрийн төсөвт тусгагдан батлагдсан хөрөнгө;

7.1.2. Олон Улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төсөл хөтөлбөр, хандив, буцалтгүй тусламж.

## Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

8.1.1. Хуулиар нууцад тооцогдсоноос бусад мэдээлэл нийтэд нээлттэй болсон байдал.

8.1.2. Байгууллагын цахим хуудсны баяжилт, шинэчилсэн байдал;

8.1.3. Мэдээ, мэдээлэл цаг тухай бүртээ, шуурхай тавигдсан байдал, түүний тоон үзүүлэлт;

8.1.4. Нийтэлсэн мэдээлэлтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн санал, сэтгэгдлийг хүлээн авсан байдал;

8.1.5. Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хувь, хэмжээ буурсан байдал, түүний тоон үзүүлэлт;

8.1.6. Судалгааны ажлын үр дүнг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгасан байдал;

8.1.7. Байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэмлэмжийг сайжруулсан байдал, түүний чанарын үзүүлэлт;

8.1.8. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй байдал;

8.1.9. Хамтран ажиллах хэвлэл мэдээллийн байгууллагын тоо, түүгээр дамжуулан олон нийтэд хүрэх мэдээ, мэдээллийн чанар, тоон үзүүлэлт;

8.1.10. Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк, твиттер хуудсны дагагч, хандалтын тоон үзүүлэлт нэмэгдсэн байдал;

8.1.11. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг бэхжүүлэх, сургалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, чанарын үзүүлэлт.

## Ес. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн агуулга, бүтэц, хэрэгжилтэд 2 жил тутамд үнэлгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг жил бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

## Арав. Хөтөлбөрийн үр дүн

10.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Иргэд, олон нийт мэдээ, мэдээллийг нэг дороос, чирэгдэлгүй, түргэн шуурхай авах боломж нэмэгдэж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилт өргөн хүрээнд, хүртээмжтэйгээр олон нийтэд хүрч, байгууллагын ил тод, нээлттэй байдал хангагдана.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад итгэх иргэдийн үнэлэмж дээшилж, эерэг зөв хандлагатай тогтоно.

- Мэдээ, мэдээлэл, контентууд мэргэжлийн түвшинд, зохих стандарт шаардлагын дагуу бэлтгэгдэнэ.

- Иргэдийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх эрх зүйн мэдлэг, мэдээлэл дээшилнэ.

- Хэвлэл мэдээллийн байгууллагатай олон талт хамтын ажиллагаа өргөжиж, мэргэшсэн сэтгүүлчид бэлтгэгдэн, байгууллагын үйл ажиллагааг зөвөөр сурталчлан таниулна.

- Алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилж, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ахиц дэвшил гарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/42 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР”- ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**(2021-2024 ОН)**

| Д/Д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 1.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг хуулийн хүрээнд олон нийтэд шуурхай, ил тод хэлбэрээр хүргэх ажлыг эрчимжүүлэх; | | | | |
| 1. | 1.1.Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийх; | 2021 оны 3-р улиралд | - Цахим хуудасны хандалтын тоо өссөн байх;<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2021 онд дэвшүүлсэн зорилтын биелэлт хангагдсан байх; | Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, технологийн хэлтэс |
| 2. | 1.2. Байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авах хэлбэрийг хялбаршуулах ажлыг эрчимжүүлэх; | 2021 оны 3-р улиралд | - Байгууллагын цахим хуудсаар үйлчлүүлсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байдал;<br>- Иргэд холбогдох мэдээ мэдээллийг түргэн шуурхай авсан байх; | Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, технологийн хэлтэс, салбар, нэгж |
| 3. | 1.3. Байгууллагын цахим хуудасны мэдээ мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах; | 2021-2024 он | - Цахим хуудаст шинэчлэлт, баяжилт тогтмол хийгдсэн байх;<br>- Цахим хуудаст байршуулсан мэдээ, мэдээллийн тоон үзүүлэлт өссөн байх;<br>- Байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэлэмж дээшлэх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | 1.4. Мэдээлэл авахыг хүссэн иргэд, байгууллагад хуулиар зохицуулснаас бусад мэдээллийг түргэн шуурхай өгөх ажлыг төв байгууллага болон салбар нэгжийн хүрээнд тогтмолжуулах | 2021-2024 он | - Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрх хангагдсан байх; | ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА, ЗУГ, ХШГ, СҮХОГ |
| 5. | 1.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын өдөр тутмын үйл ажиллагааны болон цаг үеийн шинжтэй зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний мэдээ, мэдээллийг түргэн шуурхай бэлтгэн олон нийтэд хүргэх; | 2021-2024 он | - Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулсан мэдээ, мэдээлэл, нийтлэл, ярилцлага, сурвалжилгын тоо нэмэгдсэн байх;<br>- Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст байршуулсан мэдээ мэдээллийн тоо нэмэгдсэн байх;<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| 6. | 1.6. Анги, байгууллагын хийсэн онцлох ажил, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг сар бүр авч нэгтгэн, нийтлэх | 2021-2024 он | - Мэдээ, мэдээллийг сар бүр авч нэгтгэсэн байх;<br>- Мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст байршуулах;<br>- “Сүлд инфо” сэтгүүлд мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн байх;<br>- Мэдээ, мэдээллийн архив, сан бүрдүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 7. | 1.7. Анги, байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан цаг үеийн шинжтэй ажил, арга хэмжээний мэдээ мэдээллийг телевиз, сонин, сайт, байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст байршуулах; | 2021-2024 он | - Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн төрөл, хүртээмж, тоо нэмэгдсэн байх;<br>- Салбар, нэгжийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүрсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| 8. | 1.8. Байгууллагын цахим хуудаст иргэд, олон нийт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал сэтгэгдэл илэрхийлэх, түүнд хариу өгөх нөхцөлийг бүрдүүлэх; | 2021 оны 3-р улиралд | - Санал сэтгэгдэл илэрхийлэх, түүнд хариу өгөх нөхцөл бүрдсэн байх;<br>- Санал хүсэлтэд түргэн, шуурхай хариу өгч хэвшсэн байх;<br>- Иргэдээс ирүүлэх, санал, хүсэлтийн тоо буурсан байх; | Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, технологийн хэлтэс, салбар, нэгж |
| 9. | 1.9. Иргэдийг мэдээллээр тогтвортой | 2021 он | - Санал хүсэлт авах, мэдээлэл өгөх тусгай | ХЯЭА, ШГА, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хангах чиг үүргийг тодорхой албан тушаалтанд хариуцуулан ажиллуулах; | | дугаар бүхий утас ажиллуулах;<br>- Иргэдийг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий албан тушаалтантай байх; | ХӨТЯЭА, ЗУГ, ХШГ, СҮХОГ, салбар нэгж |
| 10. | 1.10. Ажил хариуцсан нийт алба хаагчид тус тусын чиг үүргийнхээ хүрээнд мэдээллийг шуурхай өгөх эрх зүй, зохион байгуулалтыг бий болгох; | 2021-2024 он | - Иргэд мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авсан байна;<br>- Иргэд, байгууллагаас ирүүлэх өргөдөл гомдлын хувь буурсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдэлэл, олон нийттэй харилцах төв, |
| 11. | 1.11. Нийгмийн сүлжээнд тулгуурлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх суваг, гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх; | 2022 оны нэгдүгээр улиралд | - Фэйсбүүк, твитер, инстаграм, блог зэрэг суваг, сүлжээнд нийтэлсэн мэдээ, мэдээллийн төрөл, тоо нэмэгдсэн байх;<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл хүртээмжтэйгээр иргэд, олон нийтэд хүрсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдэлэл, олон нийттэй харилцах төв |
| 12. | 1.12.Иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх; | 2021-2024 он | - Байгууллагын цахим хуудасны цэсийг нэмэгдүүлэх;<br>- Байгууллагын цахим хуудаст байршуулж буй мэдээ, мэдээллийг төрөлжүүлэх;<br>- Шторк, постер бэлтгэн байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст тогтмол байршуулах;<br>- Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нээлттэй хаалганы өдөрлөгийг хууль журмын хүрээнд зохион байгуулах;<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх танилцуулга, боршур бэлтгэн түгээх ажлыг тогтмолжуулах; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| 13. | 1.13. Байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж, шийдвэрлүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах; | 2021-2022 он | - Өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн байх;<br>- Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх;<br>- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээг тогтмол мэдээллэх; | Захиргааны удирдлагын газар, салбар нэгж |
| 14. | 1.14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр иргэдийг хангах мэдээлэл авах хэсэг, орчны | 2021 он | - Мэдээллийн самбар байршуулах;<br>- Мэдээлэл авах орчныг бүрдүүлэх;<br>- Мэдээлэл өгөх хэлбэрийг цахим болгох; | ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА, ЗУГ, ХШГ, СҮХОГ, салбар нэгж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөгжүүлэлтийг хийх; | | | |
| 15. | 1.15.Иргэдийн санал хүсэлтийг тогтмол авах арга хэлбэрийг нэмэгдүүлэх; | 2021 он | - Санал хүсэлт авах хайрцаг ажиллуулах;<br>- Иргэд, байгууллагын дунд санал хүсэлт авах хайрцаг аялуулах;<br>- Санал хүсэлт авах утсыг тогтмол ажиллуулах;<br>- Цахимаар санал хүсэлт авах нөхцөлийг бүрдүүлэх; | Захиргааны удирдлагын газар, салбар нэгж |
| 16. | 1.16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд түргэн шуурхай өгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цахим программ хангамжийг шинээр боловсруулалт, хөгжүүлэлтийг хийх; | 2021-2024 он | - Цахим программын судалгааг хийж, бүтцийг тодорхойлох;<br>- Цахим программын боловсруулалтыг хийх;<br>- Цахим программ нэвтрүүлэлтийг хийх;<br>- Цахим программын ач холбогдлын талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах; | Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, технологийн хэлтэс |
| 17. | 1.17.Иргэдийг түргэн шуурхай мэдээллээр хангахгүй байх, чирэгдэл учруулах, хохироохоос урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох; | 2021-2022 он | - Иргэдэд мэдээлэл өгөх үүрэг бүхий албан тушаалтныг үүрэг чиглэлээр тогтмол хангах;<br>- Анги, байгууллагуудад үүрэг чиглэл, зөвлөмж, зөвлөгөөг тогтмол хүргүүлэх;<br>- Харилцааны ур чадвар, хариуцлагын талаарх сургалтад тогтмол хамруулах;<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн талонтай болгох; | Захиргааны удирдлагын газар |
| **ЗОРИЛТ 2.** Иргэд, олон нийтийн санаа бодол, байгууллагын үйл ажиллагаанд өгөх үнэлэмжийг тогтмол судалж, дүн шинжилгээ хийх, үр дүнг байгууллагын төлөвлөлт, бодлогын бичиг баримтад тусгах ажлыг тогтмолжуулах | | | | |
| 18. | 2.1. Байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэмлэмжийг үнэн зөвөөр судлан тогтоох аргачлалыг боловсруулан батлуулах; | 2021 оны 4 дүгээр улиралд | - Алба, газар, анги, байгууллагуудаас санал авах;<br>- Саналыг тусган аргачлалыг боловсруулан батлуулах; | Захиргааны удирдлагын газар |
| 19. | 2.2. Байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэмлэмжийг үнэн зөвөөр судлан тогтоох аргачлалын дагуу авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх; | 2022-2024 он | - Батлагдсан аргачлалын дагуу иргэд, олон нийт, байгууллагаас судалгаа авах ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлуулах; | Захиргааны удирдлагын газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20. | 2.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн үнэлэмжийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж, тогтмолжуулах; | 2022-2024он | - Иргэд, олон нийтийн үнэлэмжийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, үнэлгээг хагас жилээр хийж, дүнд тулгуурлан үр нөлөөг дээшлүүлэх, сайжруулах шаардлагатай ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн зохион байгуулсан байх;<br>- Иргэд, олон нийтийн үнэлэмжийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, үнэлгээг жилийн эцсийн байдлаар хийж, түүнээс гарсан дүнг нэгтгэн танилцуулах; | Захиргааны удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |
| 21. | 2.4. Судалгаа шинжилгээний үр дүнд суурилан өөрчлөх, сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган боловсруулан баталж, эрх зүйн зохицуулалтыг бий болгох; | 2022-2024 он | - Судалгаа шинжилгээний үр дүнд суурилан өөрчлөх, сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх; | ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА, ЗУГ, ХШГ, СҮХОГ |
| 22. | 2.5.Шүүхийн шийддвэр гүйцэтгэх байгууллагын богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаар хөгжүүлэх ажлыг тусган батлуулж, мөрдөн ажиллах; | 2021-2024 он | - Шүүхийн шийддвэр гүйцэтгэх байгууллагын богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаар хөгжүүлэх ажлыг тусган батлуулсан байх;<br>- Стратеги төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 23. | 2.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон салбар нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх, түүнийг үнэлэх, тодорхой үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах талаар бүлэг, | 2022 оны 1 дүгээр улиралд | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх, түүнийг үнэлэх, тодорхой үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах талаар бүлэг, заалт тусган батлуулах;<br>- Салбар нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын ил тод, | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | заалтыг тусгуулах; | | нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх, түүнийг үнэлэх, тодорхой үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах талаар бүлэг, заалтыг тусган батлуулах;<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж, ажилласан байх; | |
| 24. | 2.7.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулсан ажил, арга хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих; | 2022-2024 он | - Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулсан ажил, арга хэмжээ мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн байх;<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн биелэсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 25. | 2.8.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлсэн, тодорхой үр дүнд хүргэсэн ажлын хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийх; | 2022-2024 он | - Арга хэмжээнүүд нь байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, зорилго, зорилтууд, түүний хэрэгжилт, хүрч буй үр дүнтэй уялдсан байх;<br>- Арга хэмжээнүүд нь бодитой, иргэд, олон нийтэд мэдлэг, мэдээлэл болохуйц байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 26. | 2.9.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэхэд баримтлах журмыг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах; | 2021 оны 2 дугаар улиралд | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэхэд баримтлах журмыг боловсруулах<br>- Журмын төсөлд алба, газруудаас санал авч ирсэн саналыг журамд тусгах;<br>- Батлагдсан журмыг үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 27. | 2.10. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд | 2022-2024 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд /жил бүр/ байгууллагын | Захиргааны удирдлагын газар, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | шаардлагатай зардлыг санхүү, төсөвт тусгуулах; | | үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын төлөвлөгөөг батлуулах;<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн чанар хүртээмж нэмэгдсэн байх; | Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| 28. | 2.11. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон тоог шийдвэрлүүлэх; | 2022-2024 он | - Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн түвшний алба хаагчдын тоог нэмэгдсэн байх;<br>- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, тодорхой үр дүнд хүрсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| 29. | 2.12. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хангах, цар хүрээг өргөжүүлэхэд шаардлагатай техник хэрэгслийг нэмэгдүүлэх; | 2021-2024он | - Байгууллагын үйл ажиллагааны талаар нийтлэгдэж буй нэвтрүүлэг, видео контентууд мэргэжлийн түвшинд, чанарын шаардлага хангахуйцаар бэлтгэгсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, салбар нэгж |
| **ЗОРИЛТ 3.** Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай олон талт харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | |
| 30. | 3.1. Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг ил тод, нээлттэй, түргэн шуурхай авах ажлыг үр дүнд хүргэх зорилго бүхий санал солилцох уулзалтыг хэвлэл мэдээллийн бүхий л төрлийн байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг тогтмолжуулах; | 2021 оны 3 дугаар улирлаас 2024 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын хоорондын санал солилцох уулзалтыг жилд нэг удаа зохион байгуулах;<br>- Уулзалтаас гарсан санал хүсэлтийн мөрөөр ажил, арга хэмжээ зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 31. | 3.2. Байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, түүний үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах хэлэлцүүлгийг хэвлэлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | 2022 он | - Зорилтот сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлгийг жилд нэг удаа зохион байгуулсан байх;<br>- Хэлэлцүүлгээс гаргасан дүгнэлт шийдвэрүүдийг хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүргэсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 32. | 3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулах; | 2021-2024 он | - Телевиз, өдөр тутмын сонин, сайттай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан тоо нэмэгдэж, хамтын ажиллагаа өргөжсөн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | харилцах төв |
| 33. | 3.5. Телевизүүдийн хөтөлбөрт тусгах байгууллагын үйл ажиллагааны талаарх дүрст контентуудыг тогтмол бэлтгэх; | 2021-2022 он | - Иргэд, олон нийт байгууллагын үйл ажиллагааны талаарх дүрст контентуудыг тогтсон хугацаанд телевизийн сувгаар авах боломж бүрдсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 34. | 3.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг танилцуулах, салбарын ололт амжилтыг сурталчлах ажлыг тодорхой хугацаанд зохион байгуулах; | 2021 оны 3 дугаар улирлаас 2024 он | - Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл байгууллагын үйл ажиллагааны талаар тодорхой ойлголттой болж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэх сөрөг, ташаа мэдээ мэдээллийн тоо буурах;<br>- Байгуулагын архивт баяжилт хийгдсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 35. | 3.7.Мэргэжлийн чиглэл тус бүрийн онцлогийг харуулсан хөтөлбөр, аян, зорилтот контентуудыг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | 2022-2024 он | - Мэргэжлийн чиглэл тус бүрийн үр нөлөө дээшилж, байгууллагад итгэх иргэдийн тоо нэмэгдсэн байх;<br>- Байгуулагын архивт баяжилт хийгдсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| **ЗОРИЛТ 4.** Иргэд, олон нийтэд хүргэж байгаа байгууллагын үйл ажиллагааны талаар бэлтгэн боловсруулж буй мэдээ, мэдээллийн төрөл, арга хэлбэр, нийтлэлийн бодлогыг шинэчилж, мэргэжлийн түвшинд хүргэх замаар агуулга, хүртээмжийг сайжруулах | | | | |
| 36. | 4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлт, үр дүнгийн талаарх мэдээллийг агуулсан видео контент бэлтгэн нийтлэх; | 2021-2024 он | - Хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байх;<br>- Байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө дээшилж, эерэг зөв хандлагатай иргэдийн тоог нэмэгдүүлэх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 37. | 4.2. Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, сурвалжилга, ярилцлага, нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэн өдөр тутмын сонин, сайтад нийтлүүлэх; | 2021-2024 он | - Байгууллагын ил тод байдал хангагдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрэх мэдээ, мэдээллийн төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 38. | 4.3.Телевиз /дотооддоо үйл ажиллагаа явуулдаг/, радио, fm, фэйсбүүк, твитер, инстеграм, влог, подкастад зориулсан мэдээ, мэдээллийг төрөлжүүлэн бэлтгэн | 2021-2022 он | - Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл түргэн шуурхай, жигд хүртээмжтэйгээр иргэд, олон нийтэд хүрэх;<br>- Мэдээ, мэдээллийн агуулга, чанар мэргэжлийн түвшинд бэлтгэгдэн | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | түгээх; | | нийтлэгдсэн байх; | |
| 39. | 4.4. Алба хаагчдын ажил, албаны үйл ажиллагааны талаар фото сурвалжилга бэлтгэн өдөр тутмын сонин, сайт болон байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст нийтлэх ажлыг тогтмолжуулах; | 2021 он | - Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 40. | 4.5."Сүлд инфо" сэтгүүлийн нийтлэлийн бодлого холбогдох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах; | 2021 оны 2 дугаар улиралд | - "Сүлд инфо" сэтгүүлийг эрхлэн нийтлэх журам шинэчлэгдэн батлагдсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 41. | 4.6. Шинэчлэн батлагдсан "Сүлд инфо" сэтгүүлийн журмыг мөрдөн ажиллах; | 2021-2024 он | - Алба хаагчдад хүрч буй мэдээ, мэдээллийн агуулга, чанарыг сайжруулах;<br>- Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 42. | 4.7."Сүлд инфо" сэтгүүлийн редакцын уулзалтыг зохион байгуулах; | 2021 он | -"Сүлд инфо" сэтгүүлийн зөвлөлийн гишүүдийн уулзалтыг зохион байгуулж, сэтгүүлийн үр нөлөө, цар хүрээ нэмэгдүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 43. | 4.8."Сүлд инфо" сэтгүүл эрхлэн нийтлэхтэй холбогдуулан нийт бие бүрэлдэхүүнд хэрэгцээ, шаардлагатай, тулгамдаж буй асуудлаар санал солилцох, санал, шүүмжийн мөрөөр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах; | 2021 -2022 он | - Алба хаагчид ажил мэргэжлийн чиглэлийн болон бусад хэрэгцээт мэдээ, мэдээллээр бүрэн хангагдсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 44. | 4.9. Байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааны ололт амжилтыг илэрхийлсэн онол, арга зүйн ном, товихмол, эмхэтгэл, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл гаргах ажлыг хөхиүлэн дэмжиж, сурталчлах; | 2021-2024 он | - Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд онол, арга зүйн ном, товихмол, эмхэтгэл, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээлийн загвар, эх бэлтгэлийг хийж, дэмжлэг үзүүлэх;<br>- Онол, арга зүйн ном, товихмол, эмхэтгэл, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээлийн агуулга, ач холбогдлыг | ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА, ЗУГ, ХШГ, СҮХОГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах; | |
| **ЗОРИЛТ 5.** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дотоодын сургалт, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх | | | | |
| 45. | 5.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагын хэвлэл мэдээлэл хариуцсан алба хаагчдыг чадавхжуулах, мэдээ, мэдээллийг стандарт шаардлагын дагуу бэлтгэн, түгээх чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах; | 2021-2024 он | - Алба хаагчдыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг тогтмол зохион байгуулах;<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн агуулга, чанар мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 46. | 5.2. Хэвлэл мэдээлэл хариуцсан алба хаагчдыг чадавхжуулах, гэрэл зургийг стандартын дагуу авах, орчин үеийн техник хэрэгсэлтэй харилцахад чиглэсэн зөвлөмж, гарын авлага боловсруулан гаргах; | 2021-2022 он | - Дотоод албан хэрэгцээнд ашиглагдах зөвлөмж, гарын авлагыг боловсруулан батлуулах;<br>- Алба хаагчдын техник хэрэгсэл ашиглалтын чадварыг нэмэгдүүлэх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 47. | 5.3. Алба хаагчдыг байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд зөв ойлголт өгөхүйц ажил, арга хэмжээ зохион байгуулах, сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, өргөжүүлэх чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах; | 2021-2024 он | - Сошиал маркетниг, пиарын сургалтуудыг тогтмол зохион байгуулах;<br>- Алба хаагчдын мэдлэг ур чадвар, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажил, арга хэмжээний үр дүн нэмэгдсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |
| 48. | 5.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдыг илтгэх, ярианы ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах; | 2021-2024 он | - Алба хаагчид болон ажил, албаны чиг үүрэг, онцлогийн талаар нээлттэй илэрхийлдэг болсон байх;<br>- Илтгэл, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, ярилцлагад ороход бэлтгэгдсэн байх;<br>- Телевизийн нэвтрүүлэг, мэдээ, сонин, сайтын ярилцлага, байгууллагаас бэлтгэсэн контенуудад оролцох чадвартай болсон байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 49. | 5.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль, журам, дүрмийн талаар сэтгүүлчдэд сургалт зохион байгуулах. | 2022 он | - Сэтгүүлчид байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажил албаны онцлогийн талаар өргөн мэдлэгтэй болсон байх;<br>- Алба хаагчдын ажлын ачаалал, хүндрэл бэрхшээлийн талаар эерэг зөв ойлголттой болсон байх;<br>- Байгууллагын талаарх мэдээ мэдээлэл бэлтгэхдээ үйл ажиллагаа, нэршил, мэргэжлийн үг хэллэгийг үнэн зөвөөр илэрхийлдэг болсон байх<br>- Сэтгүүлчдийн зүгээс ирүүлэх байгууллагын үйл ажиллагааг эерэг зөв талаас нь сурталчлан таниулах нэвтрүүлэг, ярилцлага, сурвалжилга, мэдээ, мэдээлэл бэлтгэх хүсэлт нэмэгдсэн байх;<br>- Байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын талаарх бодит бус сөрөг мэдээ мэдээллийн тоо буурсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв |

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР